



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 561

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2, 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Булган аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, цаашид сэргээн засварлах боломжгүй болсон 14,000,000.00 (арван дөрвөн сая) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Стандарт, хэмжил зүйн газрын дарга Г.Гантөмөр, Булган аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга Ц.Бүрэнтуяа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Б.ГАВАА



0002555

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны дүгээр сарын 20-ны өдрийн
567 дугаар тогтоолын хавсралт

**БУЛГАН АЙМГИЙН СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ
ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИН**

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Сэргээн босголтын зардал	Худалдах доод үнэ
				(төгрөг)				
1	Ниссан Х трейл, 03-30 БУА, суудлын автомашин, арлын дугаар NT30055855	2002/2011	81,500	14,000,000.00	14,000,000.00	-	2,568,600.00	4,000,000.00
Нийт				14,000,000.00 (арван дөрвөн сая)	14,000,000.00 (арван дөрвөн сая)	-	2,568,600.00 (хоёр сая таван зуун жаран найман мянга зургаан зуу)	4,000,000.00 (дөрвөн сая)